



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/523

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ын хэрэгжүүлэх зорилгоор тусгаарлан эмчлэх "Халдвартын эмнэлэг", "Уламжлалт анагаах ухааны эмнэлэг"-ийн гадна харуул хамгаалалтын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 2021 оны 11 дүгээр сарын 31-ныг хүртэл 30 хоногийн хугацаанд хэрэглэх мод, нүүрсний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 630,000 (зургаан зуун гучин мянга)-н төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, зөвшөөрсүгэй

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ц.ЧОГСОМЖАВ

231012451

Аймгийн Засаг даргын 2021 оны
 дүгээр сарын..... өдрийн
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

д/д	Байгууллага	Нүүрс /11.01-11.31/		Мод /11.01-11.31/		Бүгд
		Шуудай /30 өдөр/	Үнэ	Шуудай / 15 өдөр/	Үнэ	-
1	Халдварт	30	210,000	15	105,000	315,000
2	УАУэмнэлэг	30	210,000	15	105,000	315,000
			420,000	30	210,000	
Нийт						630,000